

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНААС 2009 ОНЫ 05 ДУГААР САРД
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:

1. Улсын Их Хурал болон Байнгын хороодын хурлаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Малчны талаар төрөөс баримтлах бодлого”-ын төслийг Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороогоор хэлэлцүүлж, УИХ-ын нэгдсэн хуралдаанаар батлуулав.
- “Тариалангийн тухай хуулинд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцүүлж, УИХ-ын нэгдсэн хуралдаанаар батлуулав.
- Малчдын эдийн засгийн боломж, нөхцлийг сайжруулах зорилгоор холбогдох хуулийн төсөлд малчдыг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Боловсруулаагүй түүхий ноолуурын экспортын татварыг чөлөөлөх тухай хуулийн төсөлтэй холбогдох танилцуулга, судалгааг Төсвийн Байнгын Хороогоор хэлэлцүүлж дэмжигдэн, УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.

2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- АНУ-ын Засгийн газар хоорондын “Мянганы сорилтын гэрээ”-нд өөрчлөлт оруулах болсонтой холбогдуулан Монголын мал аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа “Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлэв.
- “Нөөцийн шатахуун гаргах тухай”, “Хаврын тариалалтын бэлтгэл хангах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хуралдаанаар хэлэлцүүлж, 2009 оны 06 сарын 03-ны өдрийн 35 дугаар тэмдэглэл гаргуулав.
- “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу ХЗДХ-ийн сайдаас зөвшөөрөл авч, хуулийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлэв
- “Жижиг, дунд үйлдвэрийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”, Ерөнхий сайдын захирамжыг хуралдаанаар хэлэлцүүлж, 2009 оны 05 сарын 20-ны өдрийн 49 дүгээр захирамжаар батлуулав.

3. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлууд:

- “Арьс шир хөтөлбөрт нэмэлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийн танилцуулгыг хэлэлцүүлж, гишүүдээс гарсан саналыг тусган боловсруулж, санал авахаар яамдад хүргүүлэв.
- Нийт 13 аймгийн 14 цөм сүргийн үржлийн төвийн асуудлаар ажлын хэсгийн орон нутагт ажилласан дүнг танилцуулж, төрийн өмчит аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар байгуулах асуудлыг боловсруулж, ТӨХ-оор шийдвэрлүүлэхээр хүргүүлээд байна. Энэ арга хэмжээний хүрээнд Цөм сүргийн үржлийн газрын дүрмийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болоод байна.

4. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- “Мах, ноолуурын талаар баримтлах бодлогын танилцуулга”-ыг Сангийн яамтай хамтран боловсруулж Хямралын түр хороонд танилцуулав.
- Төв аймгийн Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бэлчээр нутгийг 2 жил өнжөөж ашиглахтай холбогдуулан тухайн бүс нутагт нутаглаж байгаа амьжиргааны түвшин доогуур орлоготой малчин өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах тээврийн зардал, уг отрын бэлчээрийг сайжруулах, усан хангамжийг нь нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх тухай болон холбогдох яам, орон нутгийн төр, захиргааны

- байгууллагуудаас уг арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2009 оны 1/1518 тоотоор хүргүүлэв.
- “Жижиг дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх бодлого”-ын талаар санал боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд танилцуулж, ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтов.
 - “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус үндэсний зөвлөл байгуулав.
 - ХХААХҮ-ийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулав.
 - ”Малын тэжээл” хөтөлбөрийн хүрээнд бэлчээр, хадлангийн талбайг хашиж хамгаалан, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл сонгон шалгаруулах журмыг боловсруулав.
 - ”Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх тухай төслийн баримт бичиг, түүнд тавигдах шаардлагыг боловсруулав.
 - Стратегийн нөөцийн улаанбуудайг борлуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулж, холбогдох яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2009 оны 1/1344 тоотоор хүргүүлэв.
 - “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд согтууруулах ундааны үйлдвэрлэлд хяналт, үнэлгээ хийх зааврыг боловсруулав.
 - Хүн амын дундах төмөр дутлын цус багадалт өвчнөөс сэргийлэх зорилгоор баяжуулсан гурилын хэрэглээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх талаар ЭМЯ болон UNICEF-тэй хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулж, UNICEF-т танилцуулав. Мөн Завхан аймагт хоногт 10-15 тн хүчин чадал бүхий иоджуулсан давсны үйлдвэр байгуулах техник-эдийн засгийн үндэслэлийг UNICEF-тэй хамтран боловсруулав.
 - Олон улсад мөрдөгдөж буй гурилын стандартуудыг харьцуулан судалж, “Буудайн гурил MNS 244-2003” стандартыг холбогдох газрууд болон үйлдвэрлэгч нартай хамтран шинэчлэн боловсруулав.
 - Тайландын Эрхэмсэг Гүнжийн төслийн албанаас хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуульд “Үдийн хоол” хөтөлбөрийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурлан нэвтрүүлэх загварыг турших ажлын хүрээнд Төв аймгийн Алтанбулаг сумын 11-н жилийн сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, төсөл хэрэгжих боломжийн талаарх судалгаа, хяналт үнэлгээ хийх ажлыг төслийн албатай хамтран зохион байгуулав.
 - Нийслэлийн хүн амын махны хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор худалдаанд гаргасан махны чанар, үнэ, түгээлтийн үйл ажиллагаатай танилцав. 2009 оны 5 дугаар сарын 25 өдөр Монголын махны холбоо, үйлвэрлэгч нартай уулзалт зохион байгуулан үйлдвэрлэгчдэд тулгамдсан асуудлууд болон цаашид шийдвэрлэх асуудлын талаар санал солилцлоо.
 - “Сүү” төслийн хүрээнд хэрэгжиж байгаа 22ш бага оврын сүүний цех, 20ш сүүний хөргөлтийн танк, 4ш иж бүрэн сүү боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сонгон шалгарсан аж ахуйн нэгжүүдэд олгох ажлыг зохион байгуулж байна.
 - “Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл”-ийн төслийг боловсруулж, яамдаас санал авахаар хүргүүлэв.
 - “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийн хугацааг сунгах, урьдчилсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2009 оны 1/1606 тоотоор хүргүүлэв. Мөн “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хуралдаанаар хэлэлцүүлэхээр Тэргүүн шадар сайдад 2009 оны 1/1428 тоотоор хүргүүлэв.
 - “Бөөрөнхий байцаа, өргөст хэмх, шар лууван, шар манжин, хүрэн манжин”, “Бөөрөнхий сонгино, урт сонгино”-ны үр нийлүүлэх тендэрт шалгарсан “Ногооны үр” ХХК-ийн нийлүүлсэн 7 нэр төрлийн 1377 кг үр хүлээн авах ажлыг зохион байгуулав.

- “Дугуйт трактор /80-90м.х/ нийлүүлэгчийг сонгох”, “Төмс, хүнсний ногооны хог ургамал устгах гербицид нийлүүлэгчийг сонгох”, “Химийн уринш бэлтгэх Раундап гербицид нийлүүлэгчийг сонгох” тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулав.
- “Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин нийлүүлэгчийг сонгох”, “Шувууны томуу өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуур нийлүүлэгчийг сонгох”, “Бруцеллэзийн шинжилгээний оношлуур, багаж хэрэгсэл нийлүүлэгчийг сонгох”, “Малын гоц халдварт болон халдварт 53 нэрийн өвчнийг оношлох оношлуур нийлүүлэгчийг сонгох”, “Ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл нийлүүлэгчийг сонгох” тендерүүдийг нээж, үнэлгээ хийж байна.
- “Төмсний иж бүрдэл техник бүхий дунд оврын трактор нийлүүлэгчийг сонгох”, “Хадлангийн иж бүрдэл техник бүхий бага оврын трактор нийлүүлэгчийг сонгох”, “Газрын доорхи усны геофизикийн хайгуулын ажлын гүйцэтгэгч сонгох”, “Адууны халдварт цус багадаа өвчний шинжилгээний оношлуур, багаж хэрэгсэл худалдан авах”, “2009 онд аймаг дундын отрын бүс нутгуудад шинээр инженерийн хийцтэй худаг гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгох” тендерийн баримт бичгийг тус тус боловсруулж, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарлаад байна.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:

- Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2009 онд үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээнд хамрагдах аймаг, сум, тэмцэх талбайн хэмжээ, түүнд шаардагдах зардлын хуваарийг боловсруулж батлуулав. Энэ ажлын хүрээнд эхний ээлжинд энэ оны 5-6 дугаар сард нийт 9 аймгийн 250.0 мянган га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар оготнотой тэмцэх ажлыг гүйцэтгүүлэх тухай гэрээг аймгуудын ХХААЖДҮГ-тай байгууллаа.
- ”Малын тэжээл” хөтөлбөрийн хүрээнд энэ онд тэжээлд зориулж тариалахаар 10 аймагт нийт 142 тонн хошуу будаа, царгас, хөх тарианы үрийг хуваарилан олгоод байна.
- Бэлчээрийн зохистой менежментийн үйл ажиллагааг дээшлүүлэх, чадавхийг сайжруулах зорилгоор “Монголын бэлчээрийн менежментийн холбоо” Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.
- Тус яамны захиалгаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй царцааны тархалт хөнөөлийн тодотгох судалгааг Баян-Өлгий аймгийн 11, Ховд аймгийн 8 сумын бэлчээр нутагт энэ оны 5 дугаар сард хийсэн дүнг хэлэлцэж, судалгааны дүнг үндэслэн Баян-Өлгий аймагт 30.0 мянган га, Ховд аймагт 30.0 мянган га-д тус тус царцаатай химийн аргаар тэмцэхээр шийдвэрлээд байна.
- “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааныг зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.
- Хаврын тариалалтын ажлыг эрчимжүүлж, технологийн хугацаанд нь дуусгах ажлын хүрээнд дор дурдсан ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:
 - 2009 оны хаврын тариалалтад шаардагдах үр, хор гербицид, техникийн захиалгыг аймгийн ХХААЖДҮГ-аас авч нэгтгэн, олгох хуваарь гаргаж батлуулан, ТЭДС-ын салбаруудад хадгалж байгаа буудайн үрийг шинжилгээнд хамруулж, сангаас 9675.0тн, улсын нөөцөөс 4040.0тн, нийт 13715тн үрийг дотоодоос бэлтгэж, нийт 9,2 мянган тн үрийг 314 аж ахуйн нэгж иргэнд 30 хувийн урьдчилгаатай, 3.5 мянган тн үрийг 136 аж ахуйн нэгж, иргэнд сарын 2 хувийн хүүтэй зээлээр нийт 12,7 мянган тн үрийг 450 аж ахуйн нэгж, иргэнд олгох ажлыг зохион байгуулав. Мөн ОХУ-аас эхний ээлжинд 340тн үрийн буудай хүлээн авч, 6 аж ахуйн нэгжийн үрийн шинэчлэлтэд зориулан олгов. Ингэснээр нийт 80.0 гаруй мянган га уриншид тариалалт хийх үрээр хангав.
 - “Улсын нөөцөөс дизелийн түлш гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай” Засгийн газрын тогтоол, “Дизель түлш зээлээр олгох тухай” ХХААХҮ-ийн сайдын тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор “НИК” ХК-тай гэрээ байгуулж, 670 аж ахуйн нэгж, иргэнд 2,6 мянган литр түлшийг намрын ургацад олгох урамшууллын хөрөнгөнөөс нь суутгах нөхцлөөр зээлийн гэрээ хийж, олгосноор 185,7 мянган га талбайд тариалалт хийх 3059.0 сая төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлэв.
 - 1240 л булат 32 аж ахуйн нэгжид, 109 кг алмазис 12 аж ахуйн нэгжид, 882 тн бордоог 104 аж ахуйн нэгж иргэнд 30 хувийн урьдчилгаатай хөнгөлөлттэй

- нөхцлөөр олгож дэмжлэг үзүүлснээр 1240 тн үр ариутгах, 10.9 мянган га-гийн хог ургамал устгаж, 60.6 мянган га талбайг бордох нөхцлийг бүрдүүллээ.
- Төмсний үр олгох хуваарийг батлуулж, 85 тонн үрийг 185 гаруй өрхийн тариалан эрхэлдэг өрх, иргэн, хоршоо, байгууллагад олгов.
 - Нийслэл, орон нутгаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хүнсний ногооны үрийн хуваарийг батлуулж, Увс, Ховд, Завхан аймгаас бусад аймаг, нийслэлд хуваарийн дагуу 7 нэр төрлийн ногооны 1209.7 кг үр, иргэн өрх, хоршоо, аж ахуйн нэгжүүдэд 300кг үр олгоод байна.
 - “Жимс, жимсгэнэ” төсөл сонгон шалгаруулалтанд оролцсон 127 аж ахуйн нэгж, иргэний төслөөс 18 аймгийн 30 аж ахуйн нэгж, хоршоо, 13 иргэний төсөл, нийслэлийн 7 дүүргийн 22 аж ахуйн нэгж, 5 иргэний төслийг сонгон шалгаруулж нийт 835 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлүүлж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.
 - 5 га-гийн услалтын системийг 7 аж ахуйн нэгжид борлуулж, ТЭДС-д 27.2 сая төгрөг оруулав. Ингэснээр жижиг аж ахуйн нэгж, өрхийн 35 га тариалангийн талбайг усжуулах нөхцлийг бүрдүүлэв.
 - Нийслэлийн Засаг даргатай байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу Хан-Уул дүүргийн 20га талбайд 7,0 мянган үхрийн нүд, 15,0 мянган чацарганы суулгац тарих ажлыг эхлүүлэв. Мөн 11га газар 200 хүлэмж байгуулах ажлын хүрээнд худаг гаргах, услалтын системийн зураг, төслийн ажил хийж, хашаа хороог бэлэн болгох ажлыг зохион байгуулж байна.
 - Нийслэлд төмс, хүнсний ногооны зорь байгуулах ажлын хүрээнд байршилийг тогтоох зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
 - “Атрын III аян” тариалангийн үндэсний хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Монгол телевизээр нээлттэй хэлэлцүүлгийг 3 удаа, Монголын радиогоор 10 удаа нэвтрүүлэг явуулав
- ОХУ-аас зээлээр 19 ширхэг ХАА-н техникийг эхний ээлжинд хүлээн авч, аж ахуйн нэгжүүдэд зээлийн гэрээ байгуулан олгох ажлыг зохион байгуулав. ОХУ-аас беларус-1221.2 трактор 99ш, беларус 826 трактор 48ш, ВТЗ 2032А трактор 46ш, анжис, сийрүүлүүр тус бүр 30ш, үрийн буудай 8000 тн-ийн ачуулах хүлээн авах ажлыг ОХУ-ын “Рос Агро Лизинг” ХК-тай хамтран зохион байгуулж байна.
 - БНХАУ-ын Шанхай групптэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд нийт 100.0 мянган га талбайг усжуулах, үүнээс 2009 онд 6.0 мянган га-г усжуулах, 80.0 мянган тн-ын хүчин чадалтай элеватор барьж байгуулах, 100-гаас дээш морины хүчин чадалтай зүтгэх хүч нийлүүлэх зэрэг нийт 200.0 сая ам долларын хөрөнгө оруулалтыг 10 жилийн хугацаатай зээлээр авч, хэрэгжүүлэх гэрээ байгуулав.
 - “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгох зээлийг арилжааны банкаар дамжуулан зээлдүүлэх төслийг сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааны журам”-ийг ХХААХҮ-ийн сайдын 107 тоот тушаалаар батлуулав.
 - Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд Улаанбаатар хот, Булган, Сэлэнгэ, Төв аймгийн мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийн 50 гаруй удирдах ажилтнууд болон УИХ-ын БОХХАА-н байнгын хороо, БОАЖЯ, Ойн газар, УМХЕГ, Монголын ажил олгогч эздийн холбоо, НМХГ-ын холбогдох ажилтнууд оролцлоо. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж болон УИХ-ын 2000 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар хотод мод боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, техник технологийн байдал, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг УИХ-ын БОХХААБХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
 - Өмнөговь, Говь-Алтай аймгуудад зохион байгуулсан ЖДҮ эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцон мэдээлэл хийж, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих “Говь-Алтай” төвийн нээлтийг 2009 оны 05 сарын 16-ны өдөр хийв.
 - “Харгиа” ХК-ийн урьдчилан цэвэрлэх байгууламжийн өмчлөлийн асуудлыг Улаанбаатар хотын захиргаатай хамтран шийдвэрлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Улсын мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран арьс шир

- боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанарын байдалд шалгалт хийж, “Харгиа” ХК-ийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг хамруулав.
- “Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөрийн хүрээнд 2009 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө болон төсвийг Монголын хэвлэлийн үйлдвэрлэлийн холбоотой хамтран боловсруулан 2009 оны 05 сарын 08-ны өдөр яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.
 - БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо 2009 оны 5 дугаар сарын 12-16-ны хооронд зохиогдсон хэвлэлийн техник тоног төхөөрөмж, технологийн “China Print-2009” үзэсгэлэн, худалдаанд Монголын хэвлэлийн үйлдвэрийн салбарын төлөөллийг оролцуулах ажлыг Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоотой хамтран зохион байгуулснаар үзэсгэлэнд хэвлэлийн үйлдвэрүүдийн 62 төлөөлөл оролцож, БНХАУ-ын хэвлэлийн зарим жижиг, дунд үйлдвэрүүдтэй танилцаж, туршлага судлав.
 - Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын хүрээнд боловсруулагдсан төслүүдийг хэвлүүлэн 20000 ширхэг товхимлыг төрийн удирдлагууд болон Засгийн газрын гишүүдэд илгээж, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаар дамжуулан бизнес эрхлэгчдэд хүргэж байна.
 - Гар худаг гаргах арга технологид сургах, цас борооны усыг ашиглах тухай семинарыг зохион байгуулж, Улаанбаатар хот болон 21 аймгаас 40 орчим хүн оролцож, “Усны нөөцийг хуримтлуулах арга технологи”, “Усны нөөцийг судлах, хамгаалах тухай”, “Гар худаг гаргах ажлыг орон нутагт хэрэгжүүлэгч нарт өгөх зөвлөмж”, “Говийн бүс нутагт гар худаг гаргах заавар” зэрэг сэдвээр хэлэлцүүлэг хийв.
 - Улаанбаатар хот, төвийн бүсийн “Малын үржлийн ажлыг шинэчлэн сайжруулах” төсөлд хамрагдсан 221 аж ахуйн 5780 үнээний амьдын жинг тодорхойлоод байна. Урьдчилсан дүгээр Хар тарлан үүлдрийн үнээний амьдын жин 361.9 кг, Симменталынх 371 кг, Алатау үүлдрийнх 386.5 кг дундаж үзүүлэлттэй байна.
 - Зохиомол хээлтүүлгийн техникчдийн нэгдсэн семинарыг 5 дугаар сарын 26- ны өдөр зохион байгуулав.Семинарт яамны МААБХЗГ- ын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагчийг урилгаар оролцож, оролцогчдын тавьсан санал, асуултад хариу өглөө.
 - Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн түшиц аж ахуйг Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байгуулахтай холбогдуулан 2009 онд хийх ажлын чиглэл гарган, газар эзэмших эрхийн бичгийг авч, шаардагдах машин техник, хүлэмж, тариалах ургамал, үр, бордоо болон хөрөнгө, зардлын талаар санал, тооцоо боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар

- Монгол Улсын ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле тэргүүтэй албаны болон бизнесийн төлөөлөгчдийн Бүгд Найрамдах Болгар Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.
- НҮБ-ын ХХААБ-тай хэрэгжүүлж буй “Хүнсний үнийн хөөрөгдөлд өртөгдсөн бага орлоготой өрхийн аж ахуйнуудыг дэмжих” төслийн хүрээнд үр шим хүртэгчдэд хүнсний ногоо, тухайлбал: шар лууван, өргөст хэмх, шар манжин, хүрэн манжин, сонгины үр олгох үйл ажиллагааг зохион байгуулав.
- НҮБ-ын ХХААБ-д хүсэлт тавьсны дагуу “Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих” төслийн баримт бичгийг боловсруулах мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, 2009 оны 05 дугаар сарын 11-ний өдөр уг төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны талаар семинар зохион байгуулав.
- ОХУ-ын Ерөнхий сайд В.В. Путин Монгол Улсад хийсэн айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ирсэн ОХУ-ын ХАА-н сайд Е.Б.Скрынникийн ажлын уулзалтуудыг зохион байгуулж, Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай хоёр сайдын хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав.
- АНУ-ын ХАА-н департамент (USDA)-ын Бээжин дэх төлөөлөгч, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлаг (USAID)-ийн суурин төлөөгчийн орлогч, АНУ-ын Улаанбаатар дах ЭСЯ-ны Худалдааны хэлтсийн ахлах мэргэжилтэн нарын Төрийн нарийн бичгийн даргатай хийсэн уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын үеэр АНУ-ын тусламжийн хүнсний барааг захиалах, хүлээн авах механизмыг сайжруулах талаар санал солилцож, мал эмнэлэг,

- үржлийн салбар болон малын тэжээлийн чиглэлээр хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой гэж хоёр тал тодорхойллоо.
- Итали Улсын Засгийн газраас буцалтгүй тусламжаар авах 150 тонн тахианы махыг хүлээн авах арга хэмжээг Тариалан эрхлэлтийг дэмжих сантай хамтран зохион байгуулж, Сангийн яаманд шилжүүлэв.
 - ХХААХҮЯ, Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран “Салбарын өнөөгийн байдал, хамтын ажиллагаа”-ны талаар уулзалт зохион байгуулж, ХХААХҮЯ болон Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар хооронд хамтран ажиллах, харилцан ойлголцлолын Санамж бичигт ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунай, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Рашад Саиед нар гарын үсэг зурав.
 - Дор дурдсан хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнд:
 - “Ноос” дэд хөтөлбөр,
 - ”Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуй хөгжүүлэх” төсөл,
 - “Махны чанарыг сайжруулах” төсөл,
 - “Хүнсний өндөг, тахианы мах нэмэгдүүлэх” төсөл
 - “Махны үүлдрийн шувууны тэжээлийн жор, шинэ технологи” шинжлэх ухаан технологийн төсөл,
 - “Малын тэжээлийн нөөц нэмэгдүүлэх боломж” шинжлэх ухаан технологийн төсөл.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ